



**НИЙСЛЭЛИЙН
СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

┌ Хууль тогтоомж, эрх зүйн ┐
чиглэлийн сургалт семинар зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2017 оны 289 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хорооны албан хаагчдад хууль тогтоомж, эрх зүйн чиглэлийн сургалт семинарыг 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр “Хангарди” ордны 14 давхрын хурлын танхимд зохион байгуулсугай.

2. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах 480.000 /Дөрвөн зуун наян мянган/ төгрөгийг Нийслэлийн Спортын хорооны уралдаан тэмцээний сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалт семинарыг урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа /-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ТАНБОЛД



Нийслэлийн Спортын хорооны даргын 2019 оны
Арванхоёр сарын 29-ны өдрийн
А/60 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Хууль тогтоомж, эрх зүйн чиглэлийн
сургалт семинарийг зохион
байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын зардал: 1 хоног х 6цаг 30.000 төг = 180.000 төг	180.000
2.	Заал талбайн зардал	100.000
3.	Цай, кофе	100.000
4.	Бусад	100.000
Нийт дүн		480.000

Нийслэлийн Спортын хорооны даргын 2019 оны
11 дугаар сарын *29*-ны өдрийн
А/60 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Хууль тогтоомж, эрх зүйн чиглэлийн
сургалт семинарт хичээл заах багш
нарын бүрэлдэхүүн

- | | |
|----------------------------------|-------------|
| 1. ННБТСХорооны хэлтсийн дарга | А.Болдмаа |
| 2. НЗДТГ-ын ТЗУХ-ийн мэргэжилтэн | Т.Бат-Оргил |
| 3. НМТГ-ын мэргэжилтэн | О.Ариунтуяа |
| 4. НАГ-ын мэргэжилтэн | М.Төгсөө |
| 5. ХССХ ТББ-ын сэтгэл зүйч багш | Б.Номин |